



**ХЭЛЭЛЦЭЭРТ ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ,
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) үүсгэн байгуулах тухай хэлэлцээр нь тус банкны Захирагч нарын зөвлөлөөр хэлэлцэгдэн 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 259 болон 260 дугаар тогтоол батлагдаж тус хэлэлцээрийн 1 дүгээр зүйл болон 12.1 дүгээр зүйлүүдэд холбогдох өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн. Энэхүү хэлэлцээрт оруулсан өөрчлөлтүүд нь ЕСБХБ-ны дотоод засаглал, үйл ажиллагааны хүрээнд төвлөрч байгаа учир Монгол Улсад сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд харин тус банкны үйл ажиллагааг төрөлжүүлж, банкны тогтвортой байдал болон гишүүн орнуудад үзүүлэх дэмжлэгийг сайжруулна гэж үзэж байна. Түүнчлэн, хэлэлцээрт оруулсан өөрчлөлтүүд нь олон улсын санхүүгийн байгууллагуудын өмнө Монгол Улсын үүрэг хариуцлагыг бататгаж, ил тод байдал, хариуцлагын зарчмыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчдад илүү итгэл төрүүлж, хууль зүйн орчныг тогтвортой, найдвартай байлгах нөхцөлийг бүрдүүлнэ.

Монгол Улсын Их Хурал 2000 онд Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч, нэгдэн орсныг соёрхон баталсан бөгөөд үүний дараагаар 2013 онд ЕСБХБ Өмнөд болон Зүүн Газар дундын тэнгисийн бүс нутагт үйл ажиллагаагаа тэлэх зорилгоор ЕСБХБ үүсгэн байгуулах тухай хэлэлцээртээ өөрчлөлт оруулсныг мөн соёрхон баталж байсан болно.

Иймд Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу тус хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулах шаардлагатай тул хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсрууллаа.

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа,
хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь 2 зүйтэй байх ба 1 дүгээр зүйлд Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах хэлэлцээрт оруулсан нэмэлт,

өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлахыг, 2 дугаар зүйлд хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгасан болно.

Гурав.Хуулийг хэрэгжүүлснээр гарч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн сөрөг үр дагавар гарагчгүй.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн тухай

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байх бөгөөд уг хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл шаардлагагүй болно.

---00---